



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 197

Улаанбаатар хот


“Эрүүл мэндийг дэмжигч байгууллагыг
шалгаруулах болзолд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Улсын Их Хурлын 2001 оны 81 дүгээр тогтоолоор батлагдсан Нийгмийн эрүүл мэндийн талаар Төрөөс баримтлах бодлогын 3.2, 3.3 дахь чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайдын 2009 оны 184 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Эрүүл мэндийг дэмжигч байгууллагыг шалгаруулах болзол”-ын 2.1 дэх үзүүлэлтийн зарим заалтад оруулах нэмэлт, өөрчлөлтийг нэгдүгээр хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэхүү нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан 2.1, 3.1 дэх үзүүлэлтийн зарим заалтыг хоёрдугаар хавсралтаар хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Н.УДВАЛ

42
Эрүүл мэндийн сайдын 2013 оны 05 сарын 21 өдрийн 197 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГЫГ ШАЛГАРУУЛАХ БОЛЗОЛ

II. Эрүүл мэндийг дэмжих орчин		
2.1 Аюулгүй, эрүүл орчинд ажиллах, сурах, алжаал тайлах, амрах нөхцөл бололцоогоор хангагдсан байх	- Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтын ажлын байртай, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан бол 2 оноо - Мэргэжлийн тогооч, технологич, хоол зүйч, эрүүл ахуйч зэрэг боловсон хүчнээр хангагдсан бол 1 оноо - Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг горимын дагуу хадгалж, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэдэг бол 1 оноо - Чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан түүхий эдээр батлагдсан жор, технологийн дагуу хийсэн, эрүүл аюулгүй хоол, хүнсээр үйлчилдэг бол 1 оноо -Стандартын шаардлага хангасан ундны усны хүрэлцээтэй эх үүсвэртэй бол 1 оноо - Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилтан эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан, хоол үйлдвэрлэлд үйлчилгээнд мөрдөх зохистой дадлыг мөрдөж, ажиллаж хэвшсэн бол 2 оноо	1-8

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 05 сарын
21 өдрийн 197 тоот тушаалын
хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГЫГ ШАЛГАРУУЛАХ БОЛЗОЛ

Үзүүлэлт	Хүчингүй болгох шалгуур
II. Эрүүл мэндийг дэмжих орчин	
2.1 дэх "Аюулгүй, эрүүл орчинд ажиллах, сурах, алжаал тайлах, амрах нөхцөл бололцоогоор хангагдсан байх"	Байгууллага нь эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хүрэлцээтэй хүйтэн усаар хангагдсан бол 1 оноо, хүрэлцээтэй халуун усаар хангагдсан бол 2 оноо
III. Эрүүл мэндийг дэмжихэд хамт олны оролцоо ба хувь хүний зан зүйлийн өөрчлөлт	
3.1 дэх "Эрүүл мэндийн зан үйлийн эерэг өөрчлөлтийг дэмжих, урамшуулах, хамт олон болон олон нийтэд сурталчлах үйл ажиллагаа хэвшсэн байх"	Ажиллагсад тохь тухтай, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан хоолны газраар үйлчлүүлэх боломжоор хангагдсан бол 1 оноо Ажиллагсад сүү, цагаан идээ, төрөл бүрийн ногоо, жимс бүхий чанар сайтай "эрүүл" хоол хүнсээр хөнгөлөлттэй үйлчүүлдэг бол 3 оноо, цэвэр усаар хангадаг бол 1 оноо

---oOo---